



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

### Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.14 дэх заалт, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ын 2.4, Худалдан авах ажиллагааны улсын байцаагч, ахлах байцаагчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах этгээдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэй байршуулахыг Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс /Ц.Батзул/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг захиалагч нарт даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

9767 00363

Сангийн сайдын 2020 оны ... дүгээр сарын ...-ны  
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

**Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах  
этгээдийн жагсаалт**

№	Эрхээ хязгаарлуулсан этгээдийн нэр, регистрийн дугаар	Бүртгэлд хамруулсан үндэслэл	Улсын байцаагчийн шийдвэр, шүүхийн тогтоолын дугаар, огноо	Бүртгэлд хамруулсан огноо
1	“Аяга Уул” ХХК /5132347/	Нийгмийн даатгалын 27a57524-b735-42e8-9e22-9e824d61b4dc дугаартай цахим тодорхойлолт хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.09.18-ны өдрийн УБ/20 дугаар дүгнэлт	2020 оны ... <sup>10</sup> дугаар сарын ... <sup>06</sup> -ны өдөр
2	“Баттод” ХХК /5323584/	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн D2011002818, D201238325 дугаар дипломыг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.09.18-ны өдрийн УБ/21 дугаар дүгнэлт	2020 оны ... <sup>10</sup> дугаар сарын ... <sup>06</sup> -ны өдөр
3	“Эко тогтол” ХХК /5197023/	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн D201200043 дугаар дипломыг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.09.18-ны өдрийн УБ/22 дугаар дүгнэлт	2020 оны ... <sup>10</sup> дугаар сарын ... <sup>06</sup> -ны өдөр
4	“Тотал технологи” ХХК /5507065/	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тодорхойлолтыг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын ахлах байцаагчийн 2020.09.11-ний өдрийн УБ/23 дугаар дүгнэлт	2020 оны ... <sup>10</sup> дугаар сарын ... <sup>06</sup> -ны өдөр

5	“Метро консалтинг” ХХК /5977568/	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын ахлах байцаагчийн 2020.09.21-ний өдрийн УБ/24 дүгээр дүгнэлт	2020 оны ..10 дугаар сарын 06-ны өдөр
6	“Ди ди эм эс глобал” ХХК / 5777844/	Хүрээ мэдээлэл, технологийн дээд сургуулийн D201005785 дугаар дипломыг хуурамчаар үйлдсэнийг улсын байцаагч тогтоосон.	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2020.09.24-ний өдрийн УБ/27 дугаар дүгнэлт	2020 оны ..10 дугаар сарын 06-ны өдөр